



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 138

Улаанбаатар хот

Г Сургалт, дахин шалгалтын Ү
төлбөр тогтоох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 219 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд ажил үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчлах тухай журам”-ын 3.8 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд ажил үйлчилгээ явуулах эрх олгоход шаардлагатай сургалтын төлбөрийг 200,000 /хоёр зуун мянга/ төгрөгөөр, эрх олгох шалгалтад тэнцээгүй иргэдээс дахин шалгалт авах төлбөрийг 50,000 /тавин мянга/ төгрөгөөр тус тус тогтоосугай.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2008 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн “Комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах, сургалтын төлбөрийн хэмжээг тогтоох” тухай 35 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН